



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/337

Номгон


“Их богд хайрханы тэнгэрийг тайх” ёслолд
хөрөнгө зарцуулах тухай

“Цэргийн албаны тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах” журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн тахилгатай “Их Богд хайрханы тэнгэрийг тайх” ёслолын арга хэмжээнд шаардагдах зардлыг баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 2.160.000 (Хоёр сая нэг зуун жаран мянган) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010857